

2026 оны 03 сарын 12 өдөр

Дугаар 10

Улаанбаатар хот

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал зарлах тухай

Компанийн тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.4, 59.10 дахь хэсэг, 60 дугаар зүйл, 64 дүгээр зүйлийн 64.1, 64.2 дахь хэсэг, 65 дугаар зүйлийн 65.1, 65.3, 65.4, 65.5, 65.6 дахь хэсэг, 67 дугаар зүйл, 71 дүгээр зүйл, 76 дугаар зүйлийн 76.1.2, 76.1.3 дахь заалт, Банкны тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.3.4 дэх заалт, Санхүүгийн зохицуулах хорооны 2018 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн 377 тоот тогтоолын хавсралтаар батлагдсан “Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журам” болон “Худалдаа, хөгжлийн банк” ХК-ийн дүрмийн 7 дугаар зүйлийн 7.3.2 дахь заалт, 7.4, 7.7, 7.10, 7.11 дэх хэсэг, 8 дугаар зүйлийн 8.11.6 дахь заалтыг тус тус үндэслэн Худалдаа, хөгжлийн банкны Төлөөлөн удирдах зөвлөлөөс **ТОГТООХ нь:**

1. Худалдаа, хөгжлийн банк ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2026 оны 4 дүгээр сарын 29-ний өдрийн 10 цаг 00 минутад Худалдаа, хөгжлийн банкны боловсруулсан цахим хуудас болох investor.tdbm.mn-ээр дамжуулан цахимаар буюу зайны технологи ашиглан хуралдуулсугай.
2. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар дараах асуудлыг хэлэлцүүлсүгэй. Үүнд:
 - 2.1. Худалдаа, хөгжлийн банк ХК-ийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэн батлах тухай;
 - 2.2. Худалдаа, хөгжлийн банк ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгох тухай;
 - 2.3. Худалдаа, хөгжлийн банк ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн зардлыг батлах тухай.
3. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг Зохион байгуулах комиссыг энэхүү тогтоолын Хавсралт 1-т заасан бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.
4. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын мэдэгдлийг 2026 оны 3 дугаар сарын 15-ны өдрийн дотор Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо болон Монголын хөрөнгийн биржид тус тус хүргүүлэхийг Хурал зохион байгуулах комисс (Н.Нямсүрэн)-т даалгасугай.
5. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын даргаар Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга Рандолф Коппаг томилсугай.
6. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын зарыг энэхүү тогтоолын Хавсралт 3-ийн дагуу баталж, уг зарыг Монголын хөрөнгийн бирж, Худалдаа, хөгжлийн банкны цахим хуудсаар болон олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан 2026 оны 3 дугаар сарын 17-ны өдрийн дотор олон нийтэд мэдээлж, уг зарын давталтыг 2026 оны 4 дүгээр сарын 1-ний өдөр анх зарласан хэлбэрээр дахин нийтэд мэдээлэхийг Хурал зохион байгуулах комисс (Н.Нямсүрэн)-т үүрэг болгосугай.

7. Худалдаа, хөгжлийн банкны Хувьцаа эзэмшигчдийн танилцаж болох бичиг баримтын жагсаалт, уг бичиг баримттай танилцаж болох газар, хугацааг энэхүү тогтоолын Хавсралт 4-ийн дагуу баталж, танилцах боломж нөхцөлөөр хангахыг Хурал зохион байгуулах комисс (Н.Нямсүрэн)-т даалгасугай.

8. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцэх асуудлын жагсаалт, шийдвэрийн төсөл, саналын хуудас болон тэдгээртэй холбоотой баримт бичгийг 2026 оны 3 дугаар сарын 20-ны өдрийн дотор Үнэт цаасны компаниудад хэвлэмэл эсхүл цахим байдлаар хүргүүлэхийг Хурал зохион байгуулах комисс (Н.Нямсүрэн)-т үүрэг болгосугай.

9. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гарах бүртгэлийн өдрийг 2026 оны 4 дүгээр сарын 3-ны өдрөөр тогтоосугай.

10. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалтыг бүртгэлийн өдрөөс хойш ажлын 3 хоногийн дотор Монголбанканд хүргүүлэхийг Хурал зохион байгуулах комисс (Н.Нямсүрэн)-т даалгасугай.

11. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын саналын хуудасны загварыг энэхүү тогтоолын Хавсралт 5-ын дагуу баталсугай.

12. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссыг энэхүү тогтоолын Хавсралт 2-т заасан бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

13. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд урьдчилан санал хүргүүлж буй Хувьцаа эзэмшигчдийн саналын хуудсыг 2026 оны 4 дүгээр сарын 17-ны өдрөөс 2026 оны 4 дүгээр сарын 28-ны өдрийн 17:00 цаг хүртэл цахим хэлбэрээр болон Худалдаа, хөгжлийн банкны төв байран дээр цаасан хэлбэрээр хүлээн авах, Компанийн тухай хууль, холбогдох хууль тогтоомжид заасан хувьцаа эзэмшигчдийн хурлын Тооллогын комиссын хүлээсэн үүргүүдийг хэрэгжүүлэхийг Тооллогын комисс (Л.Одмаа)-т үүрэг болгосугай.

14. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар шийдвэрлэсэн асуудал болон бусад материалыг Компанийн тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль болон холбогдох хууль тогтоомжид заасны дагуу Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо, Монголын хөрөнгийн биржид хүргүүлэхийг Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга (Н.Нямсүрэн)-д үүрэг болгосугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



РАНДОЛФ КОППА